



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/424


Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хэнтий аймгийн харьяат аймаг цэргийн цол авсан бөхчүүдэд хүндэтгэл үзүүлэхэд зориулж 1.803.500 (нэг сая найман зуун гурван мянга таван зуун) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Гантулга/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Л.Батсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231011140



Аймгийн Засаг даргын 2024 оны
дугаар сарын...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Мөнгөн аяга	3	400.000	1.200.000
2	Хүндтгэл, талархал	5	100.000	500.000
3	Хадаг ааруул	2	31.750	63.500
4	Үг бичилт	2	20.000	40.000
	Дүн			1.803.500